Захиалгын хуудсын хавсралт

# ЗАХЫН ДАМЖУУЛАГЧИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР

| № | АГУУЛГА | |
|---|---|---|
| 1 | Зорилго | Ажилтнуудыг захын дамжуулагчийн засвар, үйлчилгээний чиглэлээр мэргэшүүлж, ур чадварыг нэмэгдүүлнэ. |
| 2 | Зорилт | Сургалтын хэрэгцээнд үндэслэн хамрагдах хүрээг хангаж чадахуйц чанартай, үр дүнтэй сургалтыг авах. |
| 3 | Хэрэгцээ, шаардлага | Байнгын техник үйлчилгээ, засвар шаардагддаг эд анги учир ТББ-ыг хангахын тулд ажилтнуудыг зайлшгүй дадлагажуулах шаардлагатай. |
| 4 | Сэдэв | Сургалтыг дараах сэдвүүд болон шаардлагатай бусад сэдвүүдийг нэмж явуулах;<br>• ХАБЭА-н тухай хууль, дүрэм, журам, стандарт;<br>• ХАБЭА-н менежмент, системийн тухай;<br>• Сургагч багшийг мэргэшүүлэх, арга зүйн талаарх ойлголт;<br>• Захын дамжуулагчийн ажиллагаа<br>• Захын дамжуулагчийн задаргаа, угсаргаа<br>• Захын дамжуулагчийн эвдрэл гэмтлийн төрөл, тэдгээрийг хэрхэн оношлох<br>• Хэт халуун, хүйтэнд захын дамжуулагчийг ажиллуулах горим |
| 5 | Хэлбэр | Онол болон практик хосолсон байдлаар |
| 6 | Тавигдах шаардлага | *<u>Сургалтын байгууллагад</u>*:<br>• Эрх бүхий байгууллагаас тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байх;<br>• Тухайн чиглэлээр 3-аас доошгүи жил үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай;<br>• Сүүлийн 2 ба түүнээс дээш жил уул уурхайн салбарт тухайн чиглэлээр сургалт явуулж байсан туршлагатай;<br>• Тухайн чиглэлийн мэргэшсэн, мэргэжлийн туршлагатай багш нартай байх;<br>• Цахим сургалтыг явуулж байсан туршлагатай байх;<br>• Сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлагаар хангах;<br>• Сургалтын зориулалтын анги танхим, дадлага хийх тоног төхөөрөмжтэй байх;<br>• Сургалтад хамрагдсан ажилтнуудад мэргэжлийн үнэмлэх, сертификат олгох; |
| | | *<u>Сургагч багшид</u>*:<br>• Сургагч багш нь тухайн чиглэлээр мэргэшсэн байх;<br>• Сургагч багш нь тухайн чиглэлээр 3 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай;<br>• Сургалтын хөтөлбөртэй, түүний дагуу сургалт явуулах;<br>• Илтгэх ур чадвар, багшлах ёс зүй хэм хэмжээг мөрддөг байх; |

| | | |
|---|---|---|
| | | • Холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлт, эрх зүйн зохицуулалтын хүрээнд явуулах. |
| 7 | Хамрах хүрээ | "Салбарын Техник ашиглалт, засвар механикийн хэлтсийн ажилтнууд |
| 8 | Хугацаа | 2021 оны III, IV улиралд зохион байгуулах |
| | | "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн уурхайн ээлжийн хуваариас шалтгаалан сургалтыг давтамжтай явуулах. |
| 9 | Төсөв | Сургалтын танхим, сургагч багшийн цалин, сургалтын хэрэглэгдэхүүн, мэргэжлийн үнэмлэх /сертификат/ болон бусад зардал |
| 10 | Үр дүн | Автосамосвалын явахын цахилгаан моторыг оношлох, засварлах, өндөр өртөгтэй эд ангид эвдрэл, гэмтэл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд суралцах, дадлагажих. |